



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 27 өдөр

Дугаар A/10

Хэрлэнбаян-Улаан тосгон

**Цагаан сарын баярыг хэрэг зөрчилгүй
тэмдэглэн өнгөрүүлэх тухай**

Монгол Улсын “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 25 дугаар зүйлийн 25.1 “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль” -ийн 13 дугаар зүйлийн 13.1.2, 18 дугаар зүйлийн 18.2.8, 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.16 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цагаан сарын баярыг аливаа хэрэг зөрчилгүй тэмдэглэн өнгөрүүлэх зорилгоор хариуцлагатай эргүүлд гарч ажиллах хуваарийг хавсралтаар баталсугай.
2. Хуваарьт хугацаанд эргүүлийн үүргийг хариуцлагатай гүйцэтгэхийг байгууллагуудын дарга, эрхлэгч, захирал нарт даалгасугай.
3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, эргүүл хийсэн тайланг нэгтгэн 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдөр танилцуулахыг Захирагчийн ажлын албаны дарга С.Отгонбаяр -д үүрэг болгосугай.

ЗАХИРАГЧ



Б.ЭНХЦЭЦЭГ

Тосгоны захирагчийн 2025 оны 02 дугаар сарын 27-ны
өдрийн 07.10 дугаар захирамжийн хавсралт

Цагаан сарын баяраар хариуцлагатай
эргүүлд гарч ажиллах хуваарь



2025.03.01	2025.03.02	2025.03.03	2025.03.04
Соёлын төв, Цэцэрлэг	ЕБСургууль	ЗААлба	ЭМТөв

Хариуцлагатай эргүүлийн үүргийг оройн 23⁰⁰ цаг хүртэл гүйцэтгэх бөгөөд албан байгууллагуудын галлагаанд хяналт тавих, эгнээ хороолол, гудамж талбайд архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн хүн хөлдөж осгохоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж тэмдэглэл үйлдэн мэдээг 12⁰⁰, 20⁰⁰, 23⁰⁰ цагуудад 91011124 дугаарт мессежээр хүргүүлнэ.

Эргүүлд гарч ажилласан илтгэх хуудсыг 2025.03.06-ны өдөр ЗААлбанд ирүүлнэ.